


Баянгол дүүргийн Засаг даргын тамгын
газрын 2022 оны 03 дугаар сарын 30 өдрийн
011 дугаар албан бичгийн хавсралт
1539



**ДҮҮРГИЙН УДИРДЛАГУУД БОЛОН АЛБАН ТУШААЛТНУУДЫН
ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН
/ӨССӨН ДҮНГЭЭР/**

2022 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэдтэй хийх уулзалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулан 2022 оны 1 дүгээр улиралд нийт 66 иргэнийг хүлээн авч уулзаж санал бодлыг сонссон.

Уулзалтаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой асуудлыг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан тухай бүрт нь шийдвэрлэж программд бүртгэн холбогдох хариуг өгч ажиллалаа.

Уулзалтад хамрагдсан иргэдийн асуудлыг хандалтаар нь авч үзвэл ажилд орох хүсэлт 15%, эмчилгээний мөнгөн тусламж хүссэн-14%, шагнал урамшууллын тухай 13%, хамрагдах хүсэлтүүд хамгийн их хувийг эзэлж байна.

Иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ тэднээс гаргасан шинэ санал санаачилгыг дэмжин ажиллаж дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.



1.Төрийн одон медалиар шагнуулах хүсэлт гаргасан иргэдэд бүрдүүлэх материалын талаар мэдээлэл өгч журмыг танилцуулан, эмчилгээний болон мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 15 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж болон хүнсний багц өгч дэмжлэг үзүүлсэн.

2.Дүүргийн 8-р хорооны 39-р байрны дээвэр нь олон жил засвар үйлчилгээ хийгдээгүй зундаа борооны ус ихээр ордог тул засварлаж өгнө үү гэсэн хүсэлтийн

зорилготой 21 аймаг 9 дүүрэгт сагсан бөмбөгийн талбай тохижуулахаас манай дүүрэгт энэ онд хэрэгжүүлхээр төлөвлөсний дагуу 3 байршлыг сонгож холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.

4. Дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Монголын Циркийн үүсгэн байгуулагч Ж.Раднаабазарын гудамжинд Монголын Циркчдийн холбоонд түүний хөшөө бүхий баримлыг байршуулах хүсэлт ирүүлсний дагуу Улаанбаатар төмөр зам ХНН-тэй зөвшилцөж тус гудамжны эхлэл хэсэгт УБТЗ-ын Цэрэгжүүлсэн хамгаалалттай онцгой байдлын хэлтсийн байрны хананд байршуулсан.

Бичгээр өгсөн иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч өргөдөл гомдлын нэгдсэн цахим программд бүртгэн хуулийн хугацаанд шийдвэрлэн холбогдох хариуг өгч ажилласан.

Засаг дарга болон дүүргийн удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын мэдээг улирал бүр www.bgd.mn цахим хуудсаар мэдээлж ажиллалаа.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНГӨНХУЯГ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ГЭРЭЛЭЭ